

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 23 -ны өдөр

Дугаар 21/01

Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 23-ны өдрийн 10:00 цагт эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн онлайн плафторыг ашиглан цахимаар шууд дамжуулан явуулав.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хурлын тооллогын комиссын дарга Б.Ононг хурлын ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн урив.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Б.Ононгийн танилцуулснаар:

Компанийн 1,012,715,029 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 152 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 1,062,974,743 ширхэг энгийн хувьцааны 95.27 хувь болж байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь заалт, Компанийн Дүрмийн 7-р зүйлийн 7.11-д заасныг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хурал зохион байгуулах комиссын дарга бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

1. АПУ ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. АПУ ХК-ийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах.

Түүнчлэн, хурлын зохион байгуулалт болон АПУ ХК-ийг төлөөлж хуралд оролцож буй хүмүүсийг танилцууллаа.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав [танилцуулгыг хавсаргав]. Энэхүү асуудалтай холбоотой асуулт тодруулга, санал шүүмж байвал чөлөөтэй ирүүлнэ үү гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: ТУЗ-өөс 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “АПУ групп компани 2020 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан” хэмээн дүгнэсэн болохыг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

2. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болсон үндэслэлийг танилцуулав:

- Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 сарын 27-ны өдрийн 45 тоот тогтоолоор “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, “Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах” тухай 4-р бүлгийг нэмсэн. Тус бүлэгт заасны дагуу компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлага үүссэн.

Дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийн агуулга:

Дараах заалтад доорх байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах:

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

гэснийг

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

7.2.1. танхимаар буюу хувьцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах замаар;

7.2.2. мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр;

7.2.3. танхимаар ба зайнаас хосолсон байдлаар

гэж өөрчлөх.

Дээрх хоёр асуудалтай холбоотой асуулт байвал чөлөөтэй асууна уу гэв. Асуултыг хурлын лавлах утас 76085555 дугаарын утсаар хүлээн авав.

Хувьцаа эзэмшигч Идэр: 2020 оны хувьд 2 удаа ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргалаа. Цаашид жил бүр ийнхүү 2 удаа ногдол ашиг олгох уу? Компанийн жилийн цэвэр ашгаас давсан дүнгээр ногдол ашиг олгож байгаа нь Компанид сөрөг нөлөөтэй юү? гэж асуув.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Компани сүүлийн 10 гаруй жилд олон улсын санхүүгийн байгууллагаас хатуу нөхцөлтэй зээл авч, бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийсэн. Энэ хугацаанд цэвэр ашгийн 20-оос дээшгүй хувийг ногдол ашигт хуваарилах нөхцөл үйлчилж байсан.

Харин одоо бид зээлийг бүрэн төлж дууссан тул хуримтлагдсан ашгаас санхүүжүүлж тухайн жилийн цэвэр ашгаас давсан дүнгээр ногдол ашиг тарааж байна. Энэ нь Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй, учир нь бид 3 жилийн стратеги төлөвлөгөө, мөнгөний нарийвчилсан бодлого гаргаж, сахилга баттайгаар хэрэгжүүлж ажилладаг. Цаашид компанийн үйл ажиллагаа өргөжих тусам Компанийн зүгээс, томоохон хувьцаа эзэмшигчдийн зүгээс ногдол ашгийн бодлогыг илүү сайжруулж, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангахад онцгой анхаарч ажиллана. Хагас жилээр ногдол ашиг тараах шийдвэрийг үргэлжлүүлэхийг эрмэлзэнэ, үргэлжлээд явах болов уу гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Намуунсайхан: Цар тахлын нөлөөлөл компанид тодорхой хэмжээгээр гарсан гэж ойлгож байна. Ер нь хатуу хөл хорио компанийн борлуулалтыг хязгаарлаж байгаа, энэ тал дээр компанийн зүгээс ямар арга хэмжээ төлөвлөж байна? Хууль эрх зүйн орчинд ямар өөрчлөлтүүд харагдаж байна? Архидан согтууруулахтай тэмцэх хуулийн өөрчлөлтөд үйлдвэрлэгчид саналаа тусгуулдаг уу, хэрхэн ажиллаж байна?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Цар талын нөлөөлөл мэдээж байгаа. Монгол Улс төдийгүй олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагад нөлөөлж байна. Өнөөдөр амтай бүхэн сөрөг нөлөөллийг ярьж дурдаж байна. Миний хувьд үүнийг боломж талаас нь тайлбарлахыг хүсэж байна. Засаглалынхаа хэлбэрийг зөв болгох, шийдвэр гаргах хурдаа сайжруулах, аливаа асуудалд уян хатан, хурдан байх, ирээдүйд ирж буй засаглалын өөрчлөлтийг илүү нааш нь татаж эрс өөр жишгээр амьдрах зайлшгүй шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа өөрчлөх боломж бидэнд гарч ирж байна. Энэ бол сорил боловч урт хугацаанд томоохон өөрчлөлтийн эхлэл байх болов уу гэж бодож байна.

Ер нь өнгөрсөн онд байдал хүндрээд эхлэнгүүт согтууруулах ундаа борлуулахыг хязгаарлах, 100% хорих гэх мэт олон шийдвэрийг түвшин түвшиндээ гаргалаа. Бидний хувьд барьдаг хатуу байр суурь бол хориогоор амжилт олсон газар нэгээхэн ч үгүй бөгөөд хууль бус согтууруулах ундааг зах зээл дээр борлуулах явдал хэрээс хэтрэх, хааж боох сургаар хэрэглээнээсээ давсан худалдан авалт ихээр хийх, улмаар гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавруудыг дагуулж байна. Бид согтууруулах ундааны салбарт нөлөө бүхий үйл ажиллагаа эрхэлж буйн хувьд хуулийн нэмэлт өөрчлөлтөд өөрсдийн оноо санаа, явал зөв орчинг бүрдүүлэх талаар саналаа өгсөн. Хуулийн эхний хэлэлцүүлгийг харахад асуудал руугаа нэлээн хандаж байгаа нь ажиглагдаж байна. Биднээс гадна энэ салбарт хамааралтай бүхий л бизнесийн байгууллагууд санаа оноогоо өгч зөв орчинг бүрдүүлэх талд анхаараасай гэж хүсэж байна.

Хувьцаа эзэмшигч Ануударь: Ковид-19 цар тахлын нөлөөллийг хөнгөлөх чиглэлд төрөөс хэрэглээний төлбөрийг тэглэх зэрэг зохих шийдвэрүүд гарсан. Үүнд компани хамрагдаж чадсан уу?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Энэ хөнгөлөлтөд огт хамрагдаагүй, өмнөхийн адил үйл ажиллагаагаа явуулж байна. Харин сүүний үйлдвэр АПУ Дэйри компани хөнгөлөлтөд хамрагдаж байгаа. Засгийн газрын энэ шийдвэр хүнд цаг үед компаниудад дэмжлэг болсон зөв шийдвэр гэж бид сайшааж байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Уянсайхан: Урьд нь компани ОХУ, БНХАУ зах зээлд гарах бодлого барьж байсан. Энэ бодлого хэвээрээ байгаа юу? Цаашид зах зээлээ тэлэх боломж хэр байгаа бэ? Ковидоос шалтгаалж дээрх бодлого өөрчлөгдсөн үү?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Экспортын бодлого огт өөрчлөгдөөгүй, харин ч бид илүү эрчимтэй ажиллаж байна. Өнгөрсөн 2-3 жилийн хугацаанд зөв суурийг тавьж, хууль эрх зүйн орчинд тохируулахын төлөө чамгүй ажлыг хийж байна. Жишээ тоо баримт дурдвал 1-р улирлын байдлаар ОХУ дахь борлуулалт 247%-аар, БНХАУ-д мөн өссөн үзүүлэлттэй байна.

Хувьцаа эзэмшигч Тэлмүүн: АПУ ХК олон улсын хөрөнгийн биржид хувьцаа гаргах төлөвлөгөөг нэлээн эртнээс ярьж байсан, энэ ажил хэр ахиц дэвшилтэй байна?

Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг: Манай групп компанийн бодлогод гадаадын зах зээлд IPO хийх стратеги зорилт бий. Гэвч энэ их амаргүй ажил. Зөвхөн компанийн зорилго зорилтоор тогтохгүй улс орны хууль эрх зүйн зохицуулалт шаардагддаг. Бид энэ зорилтыг биелүүлэх бэлтгэл ажлаа хангаж яваа. Экспортын чиглэлээр төрөөс явуулж буй бодлого, үндэсний компаниудаа дэмжих, хууль эрх зүйн орчны чиглэлд төрийн бодлого зохицуулалтын газруудтай хамтарч хийх ажлууд байна.

Хувьцаа эзэмшигч Баярцэцэг: Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цаашид байнга цахимаар хийх үү? Бидэнд гарын бэлэг өгдөг байсан нь цаашид яах вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Бид хувьцаа эзэмшигчдээ хуралд өргөнөөр хамруулж, компанийн удирдлагуудтай нүүр тулж асуулт тавих, компанийн бүтээгдэхүүний дээжээс хүртэх боломжоор хангахыг хичээсээр ирсэн. Гэвч сүүлийн 2 жилийн хугацаанд гадаад нөхцөл байдлаас ийм боломжгүй байгаа хэдий ч цаашид байдал хэвийн болоход танхимаар зохион байгуулах болно. Гэхдээ шаардлагатай үед хурлыг цахимаар болон эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулна. Танхимаар зохион байгуулах тохиолдолд биеэр хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ гарын бэлэг өгч, компанийн бүтээгдэхүүний дээжээс амсах боломжийг бүрдүүлнэ. Харин цахимаар болон эчнээгээр хуралдах тохиолдолд гарын бэлэг өгөх хүндрэлтэй тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг ойлгоно гэж найдаж байна.

Хувьцаа эзэмшигч Г.Оюунцэцэг: АПУ Групп компанийн удирдлага болон ажиллагсдад амжилт хүсье. Орос улсаас экспортолдог Тундра брэндийн талаар товч мэдээлэл өгнө үү. Мөн компанийн 100 жилийн ой хэзээ болох вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Тундра брэнд нь биет хэмжээгээр дэлхийд хамгийн их үйлдвэрлэгдэн, борлуулагддаг томоохон брэнд. Бид Татспиртпром компанитай стратегийн түвшинд харилцан ашигтай хамтран ажиллаж байгаа ба үүний хүрээнд Тундра брэндийг өөрийн компанид үйлдвэрлэн, зах зээлд нийлүүлж байна.

Компанийн 100 жилийн ой 2024 онд болно. Бид 100 жилийн ойгоо угтаж ямар ололт амжилтыг бүтээх вэ, нийгмийн хариуцлагаа хэрхэн дээшлүүлэх вэ, яаж хүн төвтэй зөв засаглалтай ажиллах вэ, хүмүүсээ төдийгүй салбарын хамтрагчдаа хэрхэн хөгжүүлж, зэрэг өөрчлөлтөд өөрийн хувь нэмрийг хэрхэн бий болгох вэ гэсэн чиглэлээр 4 жилийн хугацаатай хөтөлбөр гарган хэрэгжүүлж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан өөр асуулт байхгүй байгаа тул санал хураалт эхэлж буйг зарлан, хэлэлцэж буй 2 асуудалд ердийн аргаар санал хураахыг дурдав.

Санал хураалт явагдаж, дуусав.

Тооллогын комиссын дарга Б.Онон санал хураалтын дүнг танилцуулав.

АПУ ХК-ийн саналын эрхтэй нийт 1,062,974,743 ширхэг хувьцаанаас 95.27% буюу 1,012,715,029 ширхэг хувьцаа эзэмшиж буй 152 хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноос 1,012,064,085 ширхэг хувьцаа бүхий хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгч, санал хураалтын ирц 99.94% байв.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах:

Зөвшөөрсөн – 1,012,064,085 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах:

Зөвшөөрсөн – 1,012,064,085 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Хурлын шийдвэр:

1. АПУ ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан доорх дүгнэлтийг батлав.

1.1. АПУ групп компани 2020 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан.

2. АПУ ХК-ийн Дүрэмд дараах өөрчлөлтийг оруулж, батлав.

2.1. Дүрмийн 7-р зүйлийн 7.2 дахь хэсэгт “7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна” гэснийг “7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

7.2.1. танхимаар буюу хувьцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах замаар;

7.2.2. мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр;

7.2.3. танхимаар ба зайнаас хосолсон байдлаар” гэж өөрчлөх;

2.2. Өөрчлөгдсөнөөс бусад дүрмийн зүйл, заалтууд хэвээр болно.

2.3. Дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт даалгав.

Ээлжит хурлыг хаав.

Хурал 11 цаг 30 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга



Ч.Ариунсан

ХЯНАСАН:

Хурлын дарга

Ц.Эрдэнэбилэг